

# ЗЭЭЛИЙН БАТЛАН ДААЛТЫН САНГИЙН ТАЙЛАН

Банк бус санхүүгийн  
байгууллагын газар  
2022 оны 1 дүгээр улирал

### **Зээлийн батлан даалтын сангийн ерөнхий төлөв байдал**

Монгол Улсын Их Хурлаас 2012 оны 11 дүгээр сарын 06-ны өдөр Зээлийн батлан даалтын сангийн тухай хуулийг баталснаар Зээлийн батлан даалтын сан нь 2012 оны 02 дугаар сарын 10-ны өдөр байгуулагдсан. Зээлийн Батлан Даалтын Сан нь барьцаа хөрөнгийн дутагдалтай Жижиг дунд үйлдвэр эрхлэгчдэд батлан даалт гаргах ашгийн төлөө бус байгууллага юм.

2022 оны 1 дүгээр улирлын байдлаар Зээлийн батлан даалтын сангийн нийт хөрөнгө 256.9 тэрбум төгрөгт хүрч өмнөх оны мөн үеэс 3.1 хувиар буюу 7.8 тэрбум төгрөгөөр өссөн байна.

Сангийн өөрийн хөрөнгө 72.3 тэрбум төгрөгт хүрч өмнөх оны мөн үеэс 7.8 хувиар буюу 5.2 тэрбум төгрөгөөр нэмэгдсэн байна. 2022 оны 1 дүгээр улиралд нийт орлого 2.1 тэрбум төгрөг ба үүнээс 1.6 тэрбум төгрөгийн цэвэр ашигтай ажилласан байна.



Зээлийн батлан даалтын сан нь байгуулагдсанаасаа хойш нийт 1085 зээлдэгчид зээлийн батлан даалт гаргасан. 2022 оны 1 дүгээр улирлын байдлаар Зээлийн батлан даалтын сан нь 581 жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээ эрхлэгчийн 162.0 тэрбум төгрөгийн зээлд 82.4 тэрбум төгрөгийн батлан даалт гаргасан байна. Нийт батлан даалт гаргасан зээлийн 15.7 хувь нь чанаргүй зээл байгаа нь өмнөх оны мөн үеэс 2.2 хувиар, хугацаа хэтэрсэн зээл 3.3 хувь байгаа нь өмнө оны мөн үеэс 1.4 хувиар тус тус буурсан бол хэвийн зээл нийт зээлийн 81.0 хувь байгаа нь өмнө оны мөн үеэс 3.6 хувиар өссөн үзүүлэлттэй байна.

### **Хэрэгжиж буй төсөл хөтөлбөрүүд**

Зээлийн батлан даалтын сан нь 2022 оны 1 дүгээр улирлын байдлаар 14 төсөл болон банк, банк бус санхүүгийн байгууллагаас олгосон зээлд батлан даалт гаргасан байна. Үүнд:

№	Төслийн нэр	Батлан даалтын хэмжээ /төгрөг/	Зээлдэгчдийн тоо
1	Ажлын байрыг дэмжих зээл	28,456,424,392.0	208
2	Аймгийн жижиг дунд үйлдвэрлэл болон өрхийн бизнесийн үйлчилгээг дэмжих сан	49,200,000.0	4
3	Азийн хөгжлийн банкны МОН-3338 төсөл	72,302,374,681.0	378
4	АХБ-ны ажлын байр нэмэгдүүлэх төсөл	21,000,000.0	2
5	АХБ-ны хөдөө аж ахуй, хөдөөгийн хөгжлийг дэмжих төсөл	799,800,000.0	2
6	Жайка	9,711,521,120.0	56
7	Жижиг дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэх сангийн төсөл	7,864,800,700.0	94

8	Монгол 888 төсөл	1,329,045,000.0	10
9	Монсеффийн төсөл	420,000,000.0	1
10	Нийслэлийн жижиг дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэх сан	412,195,400.0	9
11	Органик Монгол хөтөлбөр	3,000,000.0	1
12	Хөгжлийн банк	2,499,900,000.0	1
13	Хүнс, хөдөө аж ахуйн яамны газар тариалангийн үйлдвэрлэлийг тогтворжуулах төсөл	546,441,900.0	2
14	Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан	161,035,000.0	54
15	Банк	15,327,610,705.0	191
16	Банк бус санхүүгийн байгууллага	65,000,000.0	2

### Зээлийн батлан даалтын сангийн үйл ажиллагаа

Сангийн батлан даалтын үлдэгдэл 2022 оны 1 дүгээр улиралд 82.4 тэрбум төгрөгт хүрч өмнөх оны мөн үеэс 24 хувиар өссөн байна. Батлан даалт гаргасан зээлийн үлдэгдэл нь 162 тэрбум төгрөгт хүрч өмнөх оны мөн үеэс 27 хувиар өссөн байна.

Нийт 581 зээлдэгчид 82.4 тэрбум төгрөгийн батлан даалт гаргаснаас 82 зээлдэгчийн 10.7 тэрбум төгрөгийн батлан даалт буюу 12.96 хувь нь чанаргүй байна.

2022 оны 1 дүгээр улиралд батлан даалтын 5 хүсэлт шинээр ирснээс 4 хүсэлтийг шийдвэрлэсэн байна.



2022 оны 1 дүгээр улирлын байдлаар Зээлийн батлан даалтын сантай нэр бүхий 6 банк, 1 банк бус санхүүгийн байгууллага хамтран ажиллаж байна.

### Батлан даалтын хувь, салбараар



Нийт батлан даалтын дүнд олгосон батлан даалтын 76% нь Улаанбаатарт, 24% нь орон нутагт олгосон байна. Нийт батлан даалт гаргасан салбараар нь ангилж үзвэл боловсруулах үйлдвэр 35%, бөөний болон жижиглэн худалдааны үйл ажиллагаа 30.3%, хөдөө аж ахуй ан агнуур ойн аж ахуй 8.2%, аялал жуулчлал зочид буудал зоогийн газар 7%, эрүүл мэнд ба нийгмийн халамжийн үйл ажиллагааны салбар 6.1%-ийг эзэлж байна.

Батлан даалтын нийт үлдэгдэлд эзлэх чанаргүй батлан даалтын хувь 13.0 болж өмнөх оны мөн үеэс 5.9 пунктээр буурсан байна. Чанаргүй батлан даалтын хэмжээ 10.7 тэрбум төгрөг болж өмнөх оны мөн үеэс 1.8 тэрбум төгрөгөөр буурсан байна.

### Чанаргүй батлан даалтын хувь, хэмжээ

